



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 24-аадар

Дугаар A/416

Мандалговь

Г Ажлын хэсэг байгуулах тухай Т

Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улаанбаатар-Мандалговь, Мандалговь-Даланзадгад чиглэлийн улсын
чанартай авто замын засвар арчлалт хариуцсан "Авто замын машин механизм"
ХХК-ийн арчлалт хамгаалалт, бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд хөндлөнгийн
хяналт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө
оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн
хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө
оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн
хэлтсийн Барилга, хот байгуулалт, дэд бүтэц
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:
-Онцгой байдлын газрын дарга
-Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн
дарга
-Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техник,
авто замын хяналтын улсын байцаагч
-Авто тээврийн төвийн дарга

Хоёр. Улаанбаатар-Мандалговь, Мандалговь-Даланзадгад чиглэлийн улсын
чанартай авто замын засвар арчлалт хариуцсан "Авто замын машин механизм"
ХХК-ийн хийсэн ажлын тайланг авч, газар дээр нь шалгаж, хөндлөнгийн хяналтыг
Зам тээврийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 9-ны өдрийн 1/5044 албан тоотын
хавсралтын дагуу шалгаж, үнэлгээг Зам, тээврийн хөгжлийн яамруу хургуулэхийг
ажлын хэсэг (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)-
т үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017
оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн А/115 дугаартай захирамжийг хүчингүй болсонд
тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



438010314

